

Нутгийн аялгууны судалгааны цаашдын чиг хандлага

Ян минху

Сонгёл их сургууль, Зүүн Азийн бизнесийн тэнхэмийн багш

1. Оршил

Нутгийн аялгууны судалгаа нь бидний мэддэг шиг томоохон бүс нутгийн аялгуу болон нийгмийн аялгуу гэж хувааж болно. Зөвхөн солонгост бүс нутгийн нутгийн аялгууны судалгаанд гол анхаарал хандуулж байгаа бөгөөд үүнтэй холбоотой олон үр дүн гарч байна.

Хэл бүрэлдэх үед эзэмшсэн хэлний онцлог нь тухайн хүний хэрэглэж буй үгийг тогтоодог гэж үздэг. Ерөнхийдөө хэлийг хэрэглэж эхэлснээс 10 гаран нас хүртлээ нэг бүс нутагт амьдарч, нутгийн аялгууны онцлогийг эзэмшсэн хүн, бусад нутгийн аялгууны нөлөөнд авталгүй нас ахисан ч их өөрчлөлт байхгүй бөгөөд өөрийн үгийг тасралтгүй хэрэглэдэг. Гэвч орчин цагт өөр бүс нутгийн хүмүүстэй харьцаа холбоогүй амьдардаг хүн бараг байхгүй. Хэл бүрэлдэн бий болсоны дараа ч тодорхой хэсэг нь бусад нутгийн аялгууны онцлогтой үгийг эзэмших болж байгаа юм.

Энэ үйл явц нь дээр үеийн хүний харьцаа холбоонд үндэслэн зөвхөн тархалт биш орчин цагийн нийгмийн онцлог тусгагдсан тархалтын аргыг багтааж байна. Орчин цагт техник технологи хөгжиж хэлний тархалтын арга урьд өмнөхөөс маш өөр болсон. Японд “Газар мөлхөж тархах”-тай адил урьдын арга биш “Тэнгэрээс бууж ирэх”-тэй адил тархалт гэж нэрлэж байна.

Залуучуудын дунд хурдацтай тархаж буй хэллэгүүдэд үндэслэн эртний бүс нутаг бүрийн хэлний ялгааг бодвол цаг үеийн хоорондох хэлний ялгаа илүү ноцтой болж байна. Энэ нь зөвхөн япон төдийгүй дэлхий даяар эсэргүүцэж болшгүй энгийн зүйл юм. Японы хувьд улс төр, эдийн засаг, соёл зэрэг хүчирхэг бүс нутгийн хэл(орон нутаг хоорондын нутгийн аялгуу) нь нийтлэг хэлтэй холбогдон хувирч байдаг ч бүрэн нийтлэг хэл болохгүй байгаа бөгөөд бүс нутгийн хэлний зогсонги байдлыг хамгаалдаг гэдэг.

Солонгос улс шиг нийслэл төвт нийгмийн бүтэцтэй бүс нутгийн хувьд нутгийн аялгууны онцлогийг хадгална гэдэг хэцүү боловч тэр дундаа бүс нутгийн нутгийн аялгууны аялга буюу дуудлага, хэллэг, үгийн илэрхийллийн зарим хэсэг нь хадгалагдахад хялбар болохыг мэдэж болно. Үүнтэй адил зүйлийг мэдэж тус тусгай дугаарт одоог хүртэл хэрэгжүүлж ирсэн нутгийн аялгууны судалгааны чиглэлд үндэслэн хойшдоо нутгийн аялгууны судалгааны цаашдын чиг хандлагыг олон бодит жишээгээр танилцуулах гэж байна.

2. Үндсэн хэсэг

Өнөөгийн нутгийн аялгууны судалгаа нь өмнө хэлсэнчлэн голдуу бүс нутгийн нутгийн аялгууны судалгаанд гол анхаарлаа хандуулж байна. Бүс нутгийн нутгийн

аялгуу нь олон судлаач хэдийн судалсан шиг анхны үгийн хэлбэр хадгалалтад утга хадгалах аргын судалгаа хийх нь гол болсон. Тийм боловч нийтийн хэл тархаснаас шалтгаалан нутгийн аялгууны хэлбэр үлдэж чадахгүй бөгөөд ул мөргүй алга болох нь ч байсан.

Ийм тохиолдолд бүс нутгийн хэлийг хамгаалалтад гол анхаарлаа хандуулвал залуучууд хооронд шинэ үгийн хэлбэрийн судалгаа хайнга болж болно. Тиймээс бүс нутгийн нутгийн аялгууны хадгалалтад ч чухал боловч цаг үе хоорондын нутгийн аялгууны судалгаа ч бас хэрэгтэй. Хойшид нутгийн аялгууны судалгаа ахих ёстой чиг хандлага бол бүс нутгийн нутгийн аялгууны судалгааг үргэлжлүүлэнгээ ийм цаг үе хоорондын ойлголцолтой холбоотой асуудалд ч гол анхаарал хандуулж байгаа юм. Японд олон нутгийн аялгууны судалгаа хийгдэж байна. Түүнээс товч үзвэл дараахтай адил юм.

2.1. Японы нутгийн аялгууны судалгааны чиг хандлага

2.1.1. Мөхөх хэл. Мөхөх нутгийн аялгуутай холбоотой асуудал

Мөхөх хэл мөн мөхөх нутгийн аялгуу гэдэг нь цаг үеийн бүс хэл, бүс нутгийн нутгийн аялгуу үгүй болох аюулд хүрсэн байна гэсэн асуудалд үндэслэн олон судалгаа хийгдэж байна. Тиймээс бүс нутгийн иргэдээс үзвэл бүс нутгийн хэл хамгаалах жишээг тэмдэглэж залгамжлах гэсэн хичээл зүтгэл байгаа боловч үүнийг бичиж задлан шинжилгээ хийх судлаачийн тоо аажмаар багасч байна гэдэг нь том асуудал болж байна. Тэгсэн ч гэсэн мөхөх нутгийн аялгууны талаар японы хадгалалтын хичээл зүтгэл бол бидэнд ч ойлгуулж буй зүйл их байна.

2.1.2. Зүүн Японы хүчтэй газар хөдлөлтийн улмаас илүү судлагдах болсон нутгийн аялгууны судалгаа

2011 оны 3 сарын 11 өдөр Зүүн Японд хүчтэй газар хөдөлсний дараа хохирол амссан бүс нутгийн талаар эмчилгээний үйл ажиллагаа болон дэмжих үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа болох үгийн сан буюу нутгийн аялгууны тайлбар товхимол боловсруулах зэрэг онцгой шинж шаардлагатай судалгааг голлон бүтээсэн боловч үүний дараа урт хугацааны алсын хараанд тус болох судалгааг эрэлхийлэхэд хүрсэн. Хохирол амссан бүс нутгийн нутгийн аялгууг хадгалах ба тэмдэглэх зорилгоор хийсэн судалгаа хийгдэх хэрэгтэй гэх яриа ихэссэн явдал юм. Тухайн үед “Нутгийн аялгууг хөгжүүлэх, нутгийн аялгуугаар хөгжих” гэсэн уриа өргөн тархах нь ч байсан.

2.1.3. Судлаачдын хамтын судалгаа ба бүс нутгийн иргэдийн нэгдэл

Японы нутгийн аялгууны судалгаа нь улам их судалсан судлаачдын хамтын судалгаа анхаар татаж байна. Зэргэлдээ орших судлаачдын хамтын судалгаагаар дамжуулан том хэмжээний хэлний газарзүйн байрлалын судалгаа ч боломжтой бөгөөд шинэ цаг үеийн үр дүнгүүд ч бас холбогдож болно гэдэгт найдаж байна. Өмнө ярьсан эргэлзээтэй нутгийн

аялгууны дадал ба хадгалалт нь зөвхөн хувь судлаачийн судалгаагаар үндэслэлгүй дутагдал нь бодит байдал юм. Бүс нутгийн хэлний тэмдэглэл ба залгамжлал нь бүс нутгийн нийгмийн төлөөлөлтэй нэгдэж байж боломжтой болох зүйл юм.

2.2. Солонгос нутгийн аялгууны судалгаа ба чиг хандлага

Солонгост ч мөхөх нутгийн аялгууны талаар хадгалалтын чухал шинжийг ойлгон эх хэлний хүрээлэнгээс бүс нутгийн хэлний авианы материал цуглуулж хот бүр бүс нутгийн хэлийг судлаж түүхэн материалуудыг дэлгэн гаргасан. Цуглуулсан материалд үндэслэн илүү их судалгаа хийхийг хүссэн боловч одоог хүртэл дутуу байна. Үүн дээр нэмээд олон янзын нийгмийн нутгийн аялгууны судалгааны чиг хандлагыг ч эрж хайх хэрэгтэй юм.

Өмнө нь Кан Жонхи(2003)нь “Нутгийн аялгууны өөрчлөлт ба нутгийн аялгууны судалгааны чиг хандлага”-д цаашдын нутгийн аялгууны судалгааны олон асуудалтай талыг илрүүлсэн. Тийм боловч 10 гаруй жил өнгөрсний дараа ч дараахтай адил нутгийн аялгууны судалгааны гол асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна.


Нэгдүгээрт: Нутгийн аялгууны судалгааны аргын асуудал байгаа болохоор хэзээг хүртэл уламжлалт нутгийн аялгуу судлалын аргаар нутгийн аялгууны судалгааг хэрэгжүүлж болох болов уу?

Хоёрдугаарт: Материалын тайлах асуудалд хам цагт нутгийн аялгууны материалд “Уламжлал хадгалсан хэлбэр”-ийг уугуул хэлээр сэргээж болох хэлний хэлбэр ба хамрах бүс нутагт үүссэн хэлний хэлбэр гэж үзэхэд юу нь уламжлалт хэлний хэлбэр мөн харьцаа холбоотой хэлбэр болохыг судлаач хэрхэн ялгаж чадах бол? Бүр цаашлаад хэдийн устаж үгүй болсон уламжлалт хэлний хэлбэр нь шинэчилсэн хэлний хэлбэртэй нийлж бүрэлдсэн Здахь холимог хэлбэрийг хэрхэн цэгцлэх зэрэг асуудлыг илрүүлсэн байна.

Ингэж илрүүлсэн агуулгууд нь бүс нутгийн нутгийн аялгууны судалгааны үед төгсгөл хүртэл сэтгэл зовниж байгаа бөгөөд цэгцлэх ёстой асуудал юм. Хэлний хэлбэр үүссэн талаарх материал тайлбар нь японы жишээ шиг судлаачдын хамтын ажил ба бүс нутгийн иргэдийн нэгдлээр дамжуулан судалгаа хийж болно гэж үзсэн. Мөн нутгийн аялгуунд анхаарал хандуулж байгаа судлаач болон жирийн иргэнд олон хавсралт материалаар хангах хэрэгтэй.

Солонгост байгаа нутгийн аялгууны талаарх удиртгал ба тайлбар бичиг маш бага байна. Бас нутгийн аялгууны талаар цогц судалгаа, авиа/авиалбар, үгийн сан, хэлзүй, толь бичиг/материал зэрэгтэй адил нутгийн аялгуутай холбоотой ном төдийгүй нутгийн аялгуутай холбоотой нийгмийн хэл шинжлэл, хэрэглээний хэлшинжлэлийн судалгаанд ч маш дутагдалтай байна. Хэрэв нутгийн аялгуутай холбоотой материал болон ном хэвлэл зэрэг элбэг болвол нутгийн аялгууны судалгааны залгамж цаг үеүд төлөвшүүлэн бүс нутгийн нутгийн аялгууны хэлбэрийн ангилал ба дүгнэлт ч бас илүү хурдацтай хөгжинө гэж үзэж байна.

Өмнө илрүүлсэн судалгааны аргын асуудлын талаар цаг үеийн урсгалд тааруулан олон янзын нутгийн аялгууны судалгаа хийх хэрэгтэй. Уламжлалт нутгийн аялгууны судалгааны аргад нийгмийн нутгийн аялгууны асуултыг оруулан судалснаар бүс нутгийн ялгаа ба дээр нь нийгмийн хэлшинжлэлийн хувирлыг ч олж харж болох зүйл юм. Үүнтэй адил оролдлого бол сүүлийн хэдэн жилийн турш олон үр дүн гарч байна гэж хэлж болно. Эх хэлний хүрээлэн 2014онд хэрэгжүүлсэн “Нутгийн аялгууны судалгааг ашиглахын тулд урт хугацааны төлөвлөгөө” төсөл Пёнтэг бүс нутгийн судалгаа дараа жил нь 2015онд хэрэгжүүлсэн “Том хот бүс нутаг нийгмийн нутгийн аялгууны судалгаа”-д бүс нутгийн нутгийн аялгууны бүлэгт нийгмийн хэлшинжлэлийн хувирлыг нийлүүлэн судлах гэсэн оролдлого харагдаж байна.



[Зураг 1] Бүс нутгийн элемент ба нийгмийн элемент нийлсэн нутгийн аялгууны судалгаа

Бодит судалгаанд ашигласан зүйлд үндэслэн цаашид нутгийн аялгууны судалгаанд ашигласан бол агуулгыг товч тайлбарлавал дараахтай адил юм.

2.2.1. Цаашид судалгаанд ашиглах боломжтой зүйл

Нутгийн аялгууны судалгаа нь өмнө дурьдсан бүс нутгийн нутгийн аялгууны судалгаанд нийгмийн нутгийн аялгууны судалгаа голлож байна. Тиймээс өнгөрсөн эх хэлний хүрээлэнгийн судалгаанд ашигласан зүйлсэд үндэслэн цаашид нутгийн аялгууны судалгаанд ашиглагдах асуудлыг дараах байдлаар ангилж болно.

- Авиа/авиалбарын холбоо хамаарал

Авианы тогтолцоо(дан эгшиг ㄹ/ㄹ, ㅍ), уйтан эгшиг/урт авиа, авианы урт богино/хөг, ”ㄴ” нэмэгдэх, хэлний урдуурх авиагаар шилжиж дуудагдах, хатуу дуудагдах, дуутай дуудагдах ба “ㄷ” нь “ㄴ” –ээр өөрчлөгдөх, эгшиг зохицох ёс, дэвсгэр үсгийн дуудлага, “ㅍ” нь “ㅍ”-ээр өөрчлөгдөх, хамжин шүргэх авианы өөрчлөлт, дэвсгэр үсгийн өөрчлөлт, хамжих авианы өөрчлөлт, “ㅍ” нь “ㅍ”-ийн өөрчлөлт, хос эгшиг “ㅍ”-ийн хувирал, “ㄷ” сүүлийн авиа хувирдаг үгийн хувирал

Авиа/авианы тогтолцоотой холбоотой зүйлс нь уламжлалт бүс нутгийн нутгийн аялгуунд тасралтгүй судлагдаж ирсэн. Зөвхөн үүнтэй адил зүйл нь бүс нутгийн өөрчлөлт дээр нийгмийн өөрчлөлтийг хайж буй чиг хандлагаар өөрчлөгдөж байна. Тиймээс цаашид судлах судалгааны байр сууринаас ч ийм бүс нутгийн авианы тогтолцоотой холбоотой судалгааг тасралтгүй хийх хэрэгтэй байна. Үгийн сангийн хувьд дараахтай адил зүйлсийг жишээгээр авч болно.

- Үгийн сангийн холбоо хамаарал

Уугуул үг мөхөх, нутгийн аялгууны тархалт, үг буруу ойлгох, хүндэтгэлийн үг, төв аялгууны тархалт, нутгийн аялгууг мэдэх, товчилсон үг, ёсорхог үг, харь үг, дуудах үг, заах үг, утга өргөжих, өвөрмөц хэлц үг, зүйр цэцэн үг

Эрт үед бүс нутаг хооронд нүүдэл буюу хүн солилцоонд үндэслэн нутгийн аялгуу нь тархсан гэвэл орчин цагт янз бүрийн үйл явцаар дамжуулан нутгийн аялгууны тархалт бий болж байна. Дээр дурьдсан үгийн сантай холбоотой зүйлийн хувьд нийгмийн хэлшинжлэлийн шинж чанарт цаг үеийн өөрчлөлт хамгийн тод илэрч байгаа учраас цаг үе хоорондын ойлголцолд саад болж болох элемент их байна.

Тиймээс иймэрхүү зүйлд цуваа цагийн судалгаа хэрэгтэй бөгөөд цаашид хэлний бодлого боловсруулахад ашиглах материал болно гэж бодож байна. Түүний дараа танилцуулах хэлзүйтэй холбоотой зүйл бол бусад зүйлтэй харицуулан нутгийн аялгууны оршин тогтнох боломж өндөр байна гэж үзэж болно.

- Хэлзүйн холбоо хамаарал

Хүндэтгэх ёс, асуух хэлбэрийн нөхцөл, үгүйсгэх асуух өгүүлбэр, үгүйсгэх өгүүлбэр, захирах өгүүлбэр

Өмнө нь японд үлдэхэд амархан нутгийн аялгуунд өгүүлбэр төгсгөх илэрхийлэл, хэмжээ заасан дайвар үг зэргийг ерөнхий хэл болгоход хэцүү зүйл гэж баталсан жишээ байдаг бөгөөд энэ нь эх хэлэнд ч уламжлалт нутгийн аялгууны хэлбэр харьцангуй хадгалагдах нь амархан гэж хэлж болно. Тиймээс бүс нутгийн нутгийн аялгууны ялгааг хамгийн сайн өөрчлөгдөж болох учраас нарийн судлах хэрэгтэй юм.

Мөн сүүлийн үед авиа/авиалбар, үгийн сан, хэлзүйтэй адил нэгжээр судалж байгаа нутгийн аялгуу биш ярианы нэгж буюу хэлний үйлдэл талаас бүс нутгийн нутгийн аялгууны ялгаа ба нийгмийн нутгийн аялгууны ялгааг судлах нь ч бий. Дараахтай адил зүйлс нь төлөөлөл жишээ юм.

- Ярианы холбоо хамаарал

Талархал илэрхийлэхэд өгөх хариулт, уучлал хүсэхэд өгөх хариулт, магтаал хэлэхэд өгөх хариулт, хүсэлт гуйлтын илэрхийлэл, хүсэлтийн талаарх татгалзал илэрхийлэх, талархлын талаарх татгалзал илэрхийлэх, гэр бүлд хүндлэл илэрхийлэх, ажлын газарт хүндлэл илэрхийлэх гомдол илэрхийлэх, зөвшөөрөл илэрхийлэх, дуудах үгийн илэрхийлэл, баттай бус илэрхийлэл

Дээрх зүйлийн талаарх судалгаа хийхэд хэлний онцлог ба хэлний үйлдлийг огтлолцлоор баталж болох аргыг хайж олох хэрэгтэй.

2.3. Нутгийн аялгууны талаарх ойлголтын өөрчлөлт

Нутгийн аялгууны тухай ойлголт ба нутгийн аялгууны үечлэл нь цаг хугацааны хамт өөрчлөгдөж байна. Заримдаа нутгийн аялгуу нь эерэг үнэлгээг авах нь ч байсан боловч мөн нэгэн цагт шударга бус үнэлгээг тэвчсэн ч өнөөг хүртэл хэвээр хадгалагдаж ирсэн бөгөөд тухайн үечлэл нь бага зэрэг өөрчлөгдөж байна.

[Хүснэгт 1] Японы нутгийн аялгууны түүх

	Шинэ үе ¹ өмнөх	Сүүлийн үе	Орчин үе	Хойшид
Нутгийн аялгуу хэрэглэх байдал	Их хэрэглэх		Багасах	Илүү багасах
Нийтийн хэл	/	Эхлэх	Ахих	Илүү ахих
Нутгийн аялгууны нийгмийн үнэлгээ	Буурах	Хэт буурах	Өсөх	
Нутгийн аялгуутай холбоотой үйл ажиллагаа	/	Устгах хөдөлгөөн	Хадгалах, дэлгэрүүлэх үйл ажиллагаа	Соёлын өв хадгалах
Нутгийн аялгууны мөн чанар	Тогтолцоо		Загвар	
Нутгийн аялгууны үүрэг	Сэтгэлгээний агуулга дамжуулах		Харилцагчийг тогтоох, ярих хандлага илэрхийлэх	

[Хүснэгт 1] –тэй адил Губаяши(2004) нь японы орчин цагийн нутгийн аялгууны онцлогийг нутгийн аялгууны хэргэлэх байдал, нийтлэг хэл ахих хэмжээ, нутгийн аялгуутай холбоотой нийгмийн үнэлгээ ба үйл ажиллагаа, нутгийн аялгууны мөн чанар болон үүрэг зэргээр ялган дараахтай адил тайлбарлаж байна. Иймэрхүү нутгийн аялгууны

¹ Японы түүхэнд Унин, Бүнмэгийн үймээний дараа Мүрумачигийн үеийн сүүлээс Эзэнт улсын үе хүртэл дамжуулж, Эду үе дуусах хүртэл шинэ үе гэж нэрлэдэг бөгөөд дэлхийн хоёрдугаар дайны өмнөх үеийг сүүл үе, түүний дараах үеийг орчин үе гэж үзэх ерөнхий үечлэл юм.

үечлэлтэй холбоотой нэгдсэн тайлбар солонгосын нутгийн аялгуунд тулгарч байгаа байр суурьтай төстэй гэж үзэж болно.

Японы хувьд сүүл үеэс өмнө нутгийн аялгууны тухай нийгмийн үнэлгээ буурсан боловч ерөнхий хэлэнд нийгэм нөлөөлөнгөө нутгийн аялгуу нь нэг илэрхийллийн загвараар өөрчлөгдөж байна. Жишээлбэл яриа нь ерөнхий хэлийг хэвээр хадгалангаа сэтгэл хөдлөл илэрхийлэл буюу өгүүлбэр төгсгөх илэрхийлэл зэрэгт нутгийн аялгууг холингоо ярианы сэдвийг удирддаг байна. Тиймээс иймэрхүү үзэгдлүүд нь орчин цагийн нутгийн аялгууны онцлог гэж үзэж болно.

Үүнтэй адил нийтлэг хэл ба нутгийн аялгууг хольж ярингаа харилцагчтай ойр байх үр дүнг үзүүлж чадна гэж үзэж байна. Одоо илүү цаашилбал илэрхийллийн(загвар) нэг хэсэг байсан нутгийн аялгуу нь “нийтлэг хэл” гэсэн өмсгөлд тохирч буй нэг төрлийн гоёл чимэглэл болж байна.

Хувцасанд гоёлын хатгуурыг зүүвэл хүмүүсийн харц хувцас биш гоёлын хатгууранд төвлөрдөг. Ингэж анхаарал татах юмуу эргэн тойронд анхаарал хандуулж байгаа үр дүнтэй нутгийн аялгууны гоёл чимэглэл орчин цагт ахиж байгааг Губаяаши нь хэлж байна. Дахин хэлбэл нутгийн аялгуу нь нийтлэг хэл шиг бүс нутгийн нийгмийн харилцах арга хэрэгслээр ашиглагдаж байсан цаг үе өнгөрч нэгэн төрлийн илэрхийллийн арга хэрэгслээр хувирсан шат хүртлээ урагшилж орчин цагт бол хүмүүсийн харцыг булаах гоё чимэглэлийн үүргийг гүйцэтгэж байна гэж хэлж болно.

Дээрхтэй адил японы нутгийн аялгууны нөхцөл байдлыг орчин цагийн солонгосын нийгмийн нутгийн аялгуунд тохируулан үзвэл дараахтай адил цаг үеэ дагаад нутгийн аялгууны дүр төрх ч бас аажмаар өөрчлөгдөж байна гэж үзэж болно. Орчин үед бид нийтлэг хэлээр ярих нь мэдээжийн цаг үед амьдарч байгаа бөгөөд нутгийн аялгууны мөхөлт нь буцаж болохгүй цаг үеийн урсгал юм. Тийм боловч нутгийн аялгууны гоёл чимэглэл нь мөн нутгийн аялгуу куспыр² нь иймэрхүү цаг үеийн нутгийн аялгууны үгийн үнэ цэнийг харамсах зүйлгүйгээр үзүүлэнгээ анхаарал татаж байна.

Хүснэгт 2. Солонгосын нутгийн аялгууны нийгмийн байдал

	1950оноос өмнө	Орчин цаг	Хойшид
Нутгийн аялгуу хэрэглэх байдал	Их хэрэглэх	Багасах	Илүү багасах
Нийтлэг хэл	/	Ахих	Илүү ахих
Нутгийн аялгууны нийгмийн үнэлгээ	Буурах	Энгийн	
Нутгийн аялгуутай холбоотой үйл	/	Хамгаалах үйл ажиллагаа эхлэх	

²Танака юүкари нь нутгийн аялгуу куспырэг тухайн бүс нутгийн уугуул иргэн биш ч гэсэн тухайн нутгийн аялгууг дуурайн ярьж байгаа үйлдэл гэж хамруулан үздэг.

ажиллагаа		
Нутгийн аялгууны үүрэг	Тогтолцоо	Загвар
Аялга үгийн үүрэг	Сэтгэлгээний агуулга дамжуулах	Харилцагчийг тогтоох, ярих хандлага илэрхийлэх

Өөрөөр бодож үзвэл орчин цагийн нийгэм бол ерөнхий хэлний нутгийн аялгууг дэмжиж, удирдаж өгч байгаа цаг үе ч гэж хэлж болно. Тиймээс иймэрхүү цаг үед амьдрангаа бидний нутгийн аялгуу үлдэж болох аргыг эрэлхийлэх нь нутгийн аялгууны тухай нийгмийн анхаарал дээшлүүлж болох судалгаа учраас хангалттай анхаарал татаж байна.

2.4. Цаашид нутгийн аялгууны талаарх судалгааны чиг хандлага

Орчин үед “нас, нийгмийн давхрага, хүйс, бүс нутаг” зэрэг олон төрлийн нийгмийн элементээс шалтгаалан өөрчлөгдсөн нийгэм юм. Тийм учраас ямар нийгмийн элемент хамаарах нийгмийн өөрчлөлтөд тохирч байгаа эсэхэд задлан шинжлэх ажилд хамаарах нийгмийг ойлгох нь маш чухал юм. Цаашид солонгосын нийгмийн бүс нутаг тус бүрт олж нээж буй насны үечлэлийн хэлний ялгааг батлаж, ойлгохгүй зүйлийг арилгах аргыг эрэлхийлэхэд эцсийн зорилго болгосон судалгаа хийх шаардлагатай байна.


Жишээлбэл японы эх хэлний хүрээлэн өнгөрсөн 60 жилийн турш 4 удаа хэрэгжүүлсэн Сирүка бүс нутгийн нийтлэг хэлний судалгаа шиг солонгост ч бас хойч ирээдүйн төлөө бүс нутаг ба нийгмийн нутгийн аялгууны талаар үргэлж анхаарал хандуулах хэрэгтэй. Хэрэв үүнтэй төстэй судалгаа хийнэ гэвэл БНСУ-ын цаашдын хэлний амьдралд тус болж болох судалгаа хийх нь тохиромжтой юм.

Солонгосын хувьд ерөнхийдөө шинэ хотын хөгжил буюу засаг захиргааны хуваах зэргээр бусад нутгийн аялгууны нөлөөнд илэрсэн бүс нутаг мөн тиймэрхүү хүнийг сонгож хэл бүрэлдэн тогтсоны дараа хэл эзэмших боломжийг эрж олохын тулд тодорхой судалгаа хийх хэрэгтэй байна.

Жишээлбэл анхны судалгааны үед 20 орчим настай байсан хүн 40 настай болох үед хэрвээ хүн хэлд орсны дараа хэл эзэмшээгүй, мөн эзэмшиж чадаагүй бол 40 орчим насны хүмүүсийн нутгийн аялгуу ба нийтлэг хэл хэрэглэх хувь нь эхний судалгааны 20 орчим насны хүний хувьтай адил байх ёстой. Иймэрхүү мөрдсөн судалгаа нь нэг хүнийг дахин судлаж байж батлах боломжтой зүйл юм. Нэг хүний талаарх адил судалгааг давтан хийхийг фанел(panel) судалгаа гэдэг. Энэ фанел судалгааг хийснээр нэг хувь хүний хэлний өөрчлөлтийг мэдэж болох бөгөөд “Хүн бол хэл эзэмших үе нь өнгөрсөн ч хэл сурдаг” болохыг баримтаар батлаж болно.

Иймээс нэг хүний амьдралын хэлний өөрчлөлтийг тогтоож чадна. Тэгвэл дараах зураг шиг нэг бүс нутгийн хэлний амьдрал, мөн нэг хүний амьдрал дахь хэлний амьдралын

өөрчлөлтийг тэмдэглэж, ойлгосноор хэлний өөрчлөлтийн загварыг бүрэн гаргаж болох зүйл юм.



[Зураг 2] Хэлний өөрчлөлтийн судалгааны загвар

3. Дүгнэлт

Юнеско нь 2009 онд дэлхийн 2500 хэл(нутгийн аялгуу) нь мөхөх аюултай байна гэж мэдээлсэн. Маш ноцтой 500 орчим хэлийг багтаасан олон тооны нутгийн аялгуу үгүй болох аюул тулгарч байна үзэж байна. Ийм байдалд хүрсэн шалтгаан бол нутгийн аялгууг хариуцах залуу үе байхгүй гэсэн ба залуу үе оршин тогтнож байгаа боловч хамаарах нутгийн аялгуу нь хойч үе хүртэл залгамжлагдахгүй зүйл гэж ярилцаж байна.

Мөн нутгийн аялгууны талаар эсрэг үзэлтэй хүмүүс нутгийн аялгуугаар өөрийн үр хүүхдийг сургадаггүй. Эмээ, өвөө нь мөн ач нартайгаа ярихдаа нутгийн аялгууг хэрэглэдэггүй бөгөөд нийтлэг хэлийг хэрэглэх гэдэг учраас хойч үед нутгийн аялгуугаар харилцах боломж аажмаар алга болох байх.

Дээр хэлсэнчлэн сүүлийн үед нутгийн аялгууны тухай үзэл бодлын өөрчлөлт бий болж байна. Өнөөг хүртэл эсэргүүцэж бодсон нутгийн аялгуу нь өөрийгөө илэрхийлэх арга хэрэгслийн нутгийн аялгуу ба гоёл чимэглэлийн нутгийн аялгуу(Губаяаши,2004), нутгийн аялгуу кустпыре(Танака,2012) зэрэгтэй адил шинээр анхаарал татаж байгаа бөгөөд дэлхий даяар эерэг нөлөө үзүүлнэ гэдэг нь талархмаар бөгөөд хүсүүштэй үр дүн гэж үзэж байна.

Тийм боловч бодит амьдралд хэрэглэж буй нутгийн аялгуу ба гоёл чимэглэлийн нутгийн аялгууны чанар өөр байна гэсэн бодолтой хүн ч бас их байна.

Нутгийн аялгуу хэрэглэсэн бүтээгдэхүүн, нутгийн аялгуугаар бичсэн самбар зэрэг гэнэт нэрд гарсан эд зүйл юмуу бизнесийн аргаар бүтээсэн гоёл чимэглэлээс хэтрэхгүй гэж эсэргүүцдэг судлаач ч байна. Мэдээж хэрвээ бүс нутгийн хэл нь нийтлэг хэл рүү нэгдэх болвол бидэнд байсан агуу бүс нутгийн соёл үгүй болсонтой холбоотой гэж үзэж болно. Гэвч нийгмийн шинж чанартай нэгдсэн бүс нутгийн нутгийн аялгууны олон талт судалгаагаар агуу бүс нутгийн соёл ба насны үечлэлийг холбож өгдөг учраас иймэрхүү хэлбэрийн нутгийн аялгууны талаар анхаарал хандуулах нь сайн гэж үзэж байна.

Цаашид нутгийн аялгууны судалгаа нь мөхөх аюулд хүрсэн бүс нутгийн нутгийн аялгуу зэргийн нарийн тэмдэглэлтэй хамт нийгмийн гол шалтгааныг нэгтгэсэн нэгдсэн

нутгийн аялгууны судалгаа нь зөв бөгөөд хэн нэгэн хийх хэрэгтэй гэвэл эх хэлний хүрээлэнгээс тэр үүргийг хүлээх ёстой гэж үзэж байна.

Номзүй

- 강정희(2003), 방언 변화와 방언 연구의 방향 《한국어학》 21, 1~15.
- 곽충구(2002), 방언 연구사 《국어국문학회 50년》(국어국문학회 엮음, 태학사)
- 민현식(1997), 국어 남녀 언어의 사회언어학적 특성 연구 《사회언어학》 5(2).
- 양민호 외(2015) 《대도시 지역사회 방언 조사》, 국립국어원 연구보고서
- 정승철(2013), 《한국의 방언과 방언학》, 태학사
- 정승철 외(2014), 《방언의 조사 활용을 위한 중장기 계획 수립》, 국립국어원 연구보고서
- 최명옥(1998), 《한국어 방언 연구의 실제》, 태학사
- 고바야시 다카시(2010), 지역어 조사 보존의 외국 사례 - 일본의 경우 - , 《새국어생활》, 제20권 제6호 가을, 57~72.
- 고바야시 다카시(2004), 액세서리로서 현대방언, 《사회언어과학》, 제7권 제1호, 105~107. / 小林隆(2004), アクセサリーとしての現代方言, 《社会言語科学》, 第7巻 第1号, 105~107.
- 기베 노부코(2015) 방언연구의 과거 현재 미래, 일본방언학회, 제100회 연구발표회 창립 50주년 기념기획 기념 심포지엄 요지문 / 木部暢子(2015), 方言研究の過去 現在 未来, 日本方言研究会第100回研究発表会, 創立50周年記念企画 記念シンポジウム予稿集.
- 다니카 유카리(2011), 《방언 코스프레의 시대》, 이와나미서점 / 田中ゆかり(2011), 「方言コスプレ」の時代, 岩波書店.
- 이노우에 후미오 저, 김덕호 외(2015) 《경제언어학 언어, 방언, 경어》, 역락

Хэвлэсэн газар: БНСУ-ын Эх хэлний академи

Сэтгүүлийн дугаар: 2016он 26-р боть 1дэх дугаар Хавар, Vol.200

Хуудас: 65-77

Орчуулсан: : Ё.Нямхишиг

2017.01.20